



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН САРЫН ТАНИЛЦУУЛГА

2025 IV



www.ubstat.mn



Улаанбаатар хот
2025 он



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2025
4 сар

АГУУЛГА

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2021-2025 он	1
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	2
	Чингэлтэй дүүргийн өрх, хүн амын 2024 оны үндсэн үзүүлэлт	2
I	Эрүүл мэнд	4
II	Нийгмийн даатгал, халамж	7
III	Гэмт хэрэг	10
IV	Дүүргийн төсөв	12
V	Хэрэглээний үнэ	15
VI	Нийтийн аж ахуй	18
VII	Аюулгүй байдал	19
VIII	Төрийн бусад үйлчилгээ	20
IX	Цаг уур, агаарын чанар, аюулт үзэгдэл, осол	24

Хүснэгт 1. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, дүүргээр		Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV
		Шинээр төрсөн хүүхэд	Хүн	591 ^{↓27.8}	636 ^{↑7.6}	660 ^{↑3.8}
		Халдварт өвчнөөр өвчлөгчид	Хүн	401 ^{↑2.7*}	343 ^{↓14.5}	441 ^{↑28.5}
		Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)	Хувь	2.9 ^{↑45.0}	0.6 ^{↓79.3}	0.3 ^{↓50}
		Дүүргийн төсвийн орлого	Тэрбум төгрөг	51.7 ^{↑70.6}	52.4 ^{↑1.4}	78.5 ^{↑49.8}
		Дүүргийн төсвийн зарлага	Тэрбум төгрөг	52.4 ^{↑2.4}	69.8 ^{↑33.2}	83.0 ^{↑18.9}
		Төгрөгийн ам.доллартай харьцах ханш, сарын эцэст	1US\$ =₮	3 469.6 ^{↑21.8}	3 381.3 ^{↓25}	3 590 ^{↑1.4}

Хүснэгт 2.		НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүүргээр											
Үзүүлэлт	Хэм- жих нэгж	2024 I-IV						2025 I-IV					
		Хотын дун- даж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хоты н дун- даж	Хамгийн өндөр		Хамгийн бага			
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	349	Баянгол	8 578	Налайх	59	357	Баянгол	8 797	Налайх	59		
			Чингэлтэй	1 526	Багануур	47		Чингэлтэй	1 490	Багануур	47		
			Сүхбаатар	679	Багахангай	32		Сүхбаатар	688	Багахангай	32		
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	13	Багахангай	29	Баянзүрх	7	16	Багануур	29	Баянзүрх	10		
			Багануур	15	Чингэлтэй	6		Сүхбаатар	19	Чингэлтэй	9		
			Сонгино- хайрхан	13	Налайх	4		Налайх	18	Багахангай	-		
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	37	Баянзүрх	43	Чингэлтэй	25	43	Багануур	42	Хан-Уул	26		
			Сүхбаатар	31	Сонгино- хайрхан	24		Баянзүрх	39	Налайх	18		
			Баянгол	30	Багахангай	5		Баянгол	34	Багахангай	13		
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	67	Баянгол	104	Багахангай	84	83	Баянзүрх	123	Налайх	91		
			Сүхбаатар	102	Налайх	75		Сүхбаатар	121	Багахангай	80		
			Чингэлтэй	102	Багануур	29		Хан-Уул	120	Багануур	26		
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	73	Сонгино- хайрхан	106	Налайх	42	119	Сүхбаатар	200	Сонгино- хайрхан	78		
			Баянгол	85	Багахангай	30		Чингэлтэй	140	Налайх	41		
			Чингэлтэй	83	Багануур	27		Баянгол	133	Багахангай	29		

Хүснэгт 3.

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ӨРХ, ХҮН АМЫН 2024 ОНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Дүүргийн дүн	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн дундаж ам бүлийн тоо ¹	Хүн ам зүйн ачаалал ²
	36 857	133 044	3.6	56.3
1 -р хороо	855	3 560	4.2	64.7
2 -р хороо	955	3 310	3.5	65.0
3 -р хороо	1 566	5 644	3.6	61.3
4 -р хороо	1 256	4 936	3.9	56.5
5 -р хороо	1 206	4 617	3.8	56.3
6 -р хороо	2 515	9 119	3.6	63.0
7 -р хороо	1 761	5 935	3.4	53.6
8 -р хороо	916	3 160	3.4	52.1
9 -р хороо	1 504	5 310	3.5	52.9
10 -р хороо	1 946	7 295	3.7	57.2
11 -р хороо	1 208	4 337	3.6	51.0
12 -р хороо	1 554	5 592	3.6	54.1
13 -р хороо	1 732	6 466	3.7	57.0
14 -р хороо	1 526	5 492	3.6	54.6
15 -р хороо	2 041	7 552	3.7	56.8
16 -р хороо	1 959	7 515	3.8	56.9
17 -р хороо	2 154	7 645	3.5	54.9
18 -р хороо	2 010	6 566	3.3	50.8
19 -р хороо	1 919	6 718	3.5	54.2
20 -р хороо	1 277	4 629	3.6	53.5
21 -р хороо	1 804	6 960	3.9	56.5
22 -р хороо	1 105	4 038	3.7	54.5
23 -р хороо	1 199	4 061	3.4	57.7
24 -р хороо	889	2 587	2.9	62.2

¹ Нэг өрхөд ногдох ам бүлийн дундаж тоо

² Нэг километр квадрат газар нутагт ногдох хүний тоо

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- ** дахин

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/




V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000
сая	=10 ⁶
тэрум	=10 ⁹
их аяд	=10 ¹²
мян	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
м ²	метр квадрат
дм ²	дециметр квадрат
км ²	километр квадрат
м ³	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
Гкал	гигакалори(=10 ⁹ калори)
с	секунд
мин	минут
мкг/м ³	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат хуудас



МЭДЭЭЛЭЛ



МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ



ЭРҮҮЛ МЭНД

2025 оны эхний 4 сард 660 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 30 (4.8%) төрөлтөөр өссөн байна.

Дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэдээгээр 2025 оны эхний 4 дүгээр сарын байдлаар 660 эх амаржиж, 660 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс төрсөн эх 30 (4.8%) мэндэлсэн хүүхэд 24 (3.8%) -өөр тус тус өссөн байна.

Хүснэгт 4.


ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, 2025 оны эхний 4 сард

Үзүүлэлт	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV	Өсөлт, бууралт 2024-2025	
				Тоо	Хувь
Амаржсан эхийн тоо	797	630	660	30	4.8
Амьд төрсөн хүүхэд	801	636	660	24	3.8
Нас барсан хүн	269	254	288	34	13.4
Эхийн эндэгдэл	-	-	-	-	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	9	4	7	3	75
1-5 настай хүүхдийн эндэгдэл	2	2	-	-	-
Амьгүй төрөлт	4	5	6	1	20.0
Гэрийн төрөлт	2	3	3	0	0
Хяналтгүй төрөлт	5	6	5	-1	-16.7

* Эх үүсвэр: ЧД-ийн Эрүүл мэндийн төвийн мэдээлэл


Зураг 1.

АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД, сараар



2025 оны эхний 4 сарын байдлаар 268275 хүн үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 12152 (4.3%) хүнээр буурсан бол эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 2058 болж 2024 оны 4 дүгээр сартай харьцуулахад 434 (17.4%) хүнээр буурчээ.

Зураг 2. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгчдийг халдварт өвчний төрлөөр нь авч үзвэл амьсгалын замын цочмог халдварт өвчин 298 (67.6%), бэлгийн замаар дамжих халдварт өвчин 110 (24.9%), гэдэсний халдварт өвчин 33 (7.5%) эзэлж байна.

Хүснэгт 5. ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн 4-р сард

Төрөл	2023 I-IV		2024 I-IV		2025 I-IV		2025 2024	
	Бодит тоо	10 000 хүнд ногдох	Бодит тоо	10 000 хүнд ногдох	Бодит тоо	10 000 хүнд ногдох	Дүн	Хувь
Дүүргийн дүн	401	28.6	343	24.5	441	32.7	98	28.6
Гепатит	6	0.4	3	0.2	4	0.3	1	33.3
Цусан суулга	24	1.7	8	0.6	11	0.8	3	37.5
Сальмоненнез	4	0.3	6	0.4	3	0.2	-3	-50.0
Хоолны хордлого	-	-	-	-	17	1.3	-	-
Менингококкт	-	-	-	-	1.0	0.1	-	-
Салхин цэцэг	128	9.1	136	9.7	137	10.2	1	0.7
Гахайн хавдар	-	-	8	0.6	-	-	-	-
Улаан эсэргэнэ	6	0.4	12	0.9	15	1.1	3	25.0
Ёлом	2	0.1	5	0.4	7	0.5	2	40.0
Бруцеллёз	-	-	-	-	-	-	-	-
Гар, хөл, ам	63	4.5	31	2.2	13	1.0	-18	-58.1
Эритема	-	-	-	-	14	1.0	-	-
Хачигт энцефалит	-	-	-	-	2.0	0.2	-	-
Хачигт риккетсиоз	-	-	-	-	-	-	-	-
Улаан бурхан	-	-	-	-	63	4.7	-	-
Ковид-19	-	-	-	-	-	-	-	-
Бусад	1	0.1	-	-	-	-	-	-
Тэмбүү	54	3.9	50	3.6	57	4.2	7	14.0
Төрөлхийн тэмбүү	-	-	-	-	-	-	-	-
Заг хүйтэн	17	1.2	9	0.6	15	1.1	6	66.7
Сүрьеэ	60	4.3	38	2.7	44	3.3	6	15.8
Мөөгөнцөр	8	0.6	4	0.3	7	0.5	3	
Трихомониаз	28	2.0	33	2.4	31	2.3	-2	-6.1
ХДХВ/ДОХ	-	-	-	-	-	-	-	-

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж

тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.




НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого энэ оны эхний 4 дүгээр сард 225.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 42.7 (15.9%) тэрбум төгрөгөөр буурч, сангийн зарлага 96.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 17.5 (22.3%) тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 3.


НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, *сангуудаар, тэрбум төгрөг*



Сангуудаар авч үзвэл тэтгэврийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 41.9 (18.6%) тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 937.6 (4.5%) сая төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 2.4 (13.6%) тэрбум төгрөгөөр буурч ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 2.4 (47.5%) тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.


Зураг 4.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар



Зураг 5.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сангуудаар, тэрбум төгрөг




Сангуудын зарлага өмнөх оны мөн үеэс тэтгэврийн даатгалын сангийн зарлага 14.8 (20.3%) тэрбум төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 1.9 (59%), ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 69.3 (14.7%) сая төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 762.5 (22.3%) сая төгрөгөөр, тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийгмийн халамжийн сангаас 2025 оны эхний 4 дүгээр сарын байдлаар 95.2 мянган хүнд 35.5 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан хүн 7.4 (7.3%) мянган хүнээр буурч, олгосон тэтгэмж 2.2 (6.6%) сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс ахмад настанд дэмжлэг хөнгөлөлт олгох 21.4 (2.0%) сая төгрөгөөр, алдар цолтон ахмад настанд, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд төрөөс олгох тусламж хөнгөлөлт 38.4 (13.6%) сая төгрөгөөр, эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эх эцэгт олгох тэтгэмж 87.2 (6.4%) сая төгрөгөөр буурсан байна.

Зураг 6.

ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, тэрбум төгрөг



Нийгмийн халамжийн тэтгэмжэнд 2025 оны эхний 4 дүгээр сарын байдлаар 2436 хүн хамрагдаж 3.9 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс хамрагдсан хүн 99 (4.2%), олгосон мөнгөн тэтгэвэр 705.6 (22.3%) сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 68980 хүн хамрагдаж 25.8 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан хүн 329 (0.5%) хүнээр, олгосон тэтгэмж 1.2 (5.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн

даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна. Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.



ГЭМТ ХЭРЭГ


Дүүргийн хэмжээнд нийт 1279 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 241(23.2%) хэргээр буурсан байна.

2025 оны эхний 4 сард 1279 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 241 (23.2%) хэргээр буурсан үзүүлэлтэй байна.

Гэмт хэргийн улмаас 246 хүн гэмтэж осолдон, 34 хүн нас барж, төр ард иргэдэд 16.7 тэрбум төгрөгийн хохирол учруулснаас 4.2 тэрбум (25.1%) төгрөгийг нөхөн төлүүлжээ.

Зураг 7.

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 30.8 хувийг залилан, 17.1 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 23.8 хувийг хулгайн, 1.6 хувийг бусдын хөрөнгө ашиглах, 5.6 хувийг хөдөлгөөний аюулгүй

байдал ашиглалтын журмын эсрэг, 2.7 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 2.2 хувийг дээрэм, 1.3 хувийг хүчин, 0.2 хувийг хүн амь, 14.8 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 6.

БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өөрчлөлт	
	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV	Тоо	Хувь
Дүүргийн дүн	1 139	1 038	1 279	241	23.2
Хүний амь	5	8	3	-5	-62.5
Хүчин	3	16	16	0	-
Дээрэм	12	15	28	13	86.7
Хулгай	190	211	304	93	44.1
Залилан	552	367	394	27	7.4
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	213	214	219	5	2.3
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	10	30	71	41	2.4**
Бусдыг амиа хорлоход хүргэх	-	6	34	28	5.7**
Бусдын хөрөнгө ашиглах	17	10	21	11	2.1**
Бусад гэмт хэрэг	137	161	189	28	17.4

Хүснэгт 7.

БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, дүүргээр

Дүүрэг	Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг			Өөрчлөлт	
	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	9 678	9 058	13 119	4 061	44.8
Багануур	71	114	189	75	65.8
Багахангай	11	10	9	-1	-10.0
Баянгол	1 735	1 780	2 277	497	27.9
Баянзүрх	2 633	1 922	3 486	1 564	81.4
Налайх	137	135	111	-24	-17.8
Сонгинохайрхан	1 470	1 445	1 770	325	22.5
Сүхбаатар	1 339	1 423	1 951	528	37.1
Хан-Уул	1 143	1 191	2 047	856	71.9
Чингэлтэй	1 139	1 038	1 279	241	23.2

2025 оны эхний 4 сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 6331 (89.0%) нь хөнгөн хэрэг, 779 (11.0%) нь хүнд хэрэг байна.

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

16. түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.



ДҮҮРГИЙН ТӨСӨВ


Дүүргийн төсвийн нийт орлого 83.0 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 5.0 тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ.

Дүүргийн төсвийн нийт орлого 2025 оны эхний 4 сарын байдлаар 83.0 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 5.0 (5.7%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн байна. Төсвийн нийт орлогын 98.8 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 0.8 хувийг татварын бус орлого, 0.3 хувийг тусламжийн орлого тус тус эзэлж байна.

2025 оны эхний 4 сарын байдлаар дүүргийн татварын орлого 82.0 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 3.4 (4.0%) тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 684.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1.2 (63.3%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн байна.

Зураг 8.

ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төгрөг



Хүснэгт 8.

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2025 оны эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого ба тусламжийн дүн	87 981.1	83 002.5	-4 978.6	-5.7%
A. Урсгал орлого	87 341.3	82 719.8	-4 621.5	-5.3%
1. Татварын орлого	85 480.0	82 035.8	-3 444.2	-4.0%
1.1. Орлогын албан татвар	75 163.5	71 563.0	-3 600.5	-4.8%
1.2. Өмчийн татвар	1 608.8	1 788.2	179.4	11.2%
1.3. Бусад татвар (төлбөр хураамж)	8 707.8	8 684.2	-23.2	-0.3%
2. Татварын бус орлого	1 861.2	684.0	-1 177.2	-63.2%
Б. Хөрөнгийн орлого	-	-	-	-
B. Тусламжийн орлого	639.8	282.6	-357.2	-55.8%

Орон нутгийн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх дүн 2025 оны эхний 4 сарын байдлаар 78.5 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 25.0 (24.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Төсвийн нийт зарлагын 6.3 хувийг

цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 0.7 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 20.4 хувийг бараа, үйлчилгээний бусад зардал 66.1 хувийг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

Зураг 9.

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая төгрөг




Хүснэгт 9.

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2025 оны эхний 4 сард, сая төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	103 507.3	78 549.2	-24 958.1	-24.1%
A. Урсгал зарлага	84 621.2	72 640.3	-11 980.9	-14.2%
1. Бараа, үйлчилгээний зардал	33 141.5	21 534.4	-11 607.1	-35.0%
1.1. Цалин, хөлс	5 980.3	4 931.4	-1 048.9	-17.5%
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	795.3	568.1	-227.2	-28.6%
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	26 365.9	16 034.9	-10 331.0	-39.2%
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	-	-	-	-
3. Татаас ба урсгал шилжүүлэг	51 479.7	51 105.9	-373.8	-0.7%
3.1. Татаас	-	-	-	-
3.2. Урсгал шилжүүлэг	51 479.7	51 105.9	-373.8	-0.7%
Б. Хөрөнгийн зардал	18 886.2	5 908.9	-12 977.3	-68.7%
Хөрөнгө оруулалт	18 882.2	5 908.9	-12 973.3	-68.7%

Зураг 10.

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая төгрөг



Ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын нэгдсэн төсөв: Улсын төсөв, орон нутгийн төсөв, ирээдүйн өв сангийн төсөв эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого: Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Төсвийн орлого: Тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Улсын төсөв: Улсын Их Хурлаас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн тэнцэл: Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.




ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар өслөө.

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2025 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 9.8 хувь, өмнөх сараас 0.3 хувиар өссөн байна.

Зураг 11.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, сараар



Хэрэглээний үнийн индекс 2025 оны 4 дүгээр сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 3.6 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 6.0 хувь, согтууруулах ундаа, тамхи бүлгийн дүн 3.0 хувь, хувцас бөс бараа гутал бүлгийн үнэ 1.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 3.9 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 3.2 хувь, тээвэр бүлгийн

үнэ 3.6 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 2.4 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 1.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 7.0 хувиар, даатгал, санхүүгийн үйлчилгээ 6.1 хувиар, бусад бараа үйлчилгээний үнэ 3.4 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.


Хүснэгт 10.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	2024 IV 2023 IV	2025 IV 2024 IV	2025 IV 2024 XII	2025 IV 2025 III
Ерөнхий индекс	6.1	9.8	3.6	0.3
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	7.5	7.1	6.0	0.9
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	4.3	5.7	3.0	0.9
Хувцас, бөс бараа, гутал	4.5	10.7	1.5	0.6
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	5.7	25.8	3.9	1.1
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	5.4	7.5	3.2	-0.2
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	8.1	5.5	2.4	0.3
Тээвэр	-0.3	5.8	3.6	-1.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	2.2	-0.4	0.0	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.9	5.3	1.6	0.4
Боловсролын үйлчилгээ	21.2	20.4	0.0	0.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	5.1	14.8	7.0	2.4
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	2.3	6.1	6.1	1.7
Бусад бараа, үйлчилгээ	14.1	11.6	3.4	0.1


Зураг 12.

ГУРИЛ, ТАЛХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн IV сард, төгрөг




Зураг 13.

ХОНЬ, ҮХРИЙН МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн IV сард, төгрөг




Зураг 14.

ТӨМС, ЛУУВАНГИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн IV сард, төгрөг



Зураг 15.

ТАРАГ, СҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн IV сард, төгрөг



Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин:

Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ):

Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

I_{ct}^L – t тайлант үеийн Ласдейресийн үнийн индекс

t – Тайлант үе

0 – суурь үе

P_t^i – i барааны тайлант үеийн үнэ

P_0^i – i барааны тайлант үеийн үнэ

q_0^i – i барааны тайлант үеийн үнэ

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан.



НИЙТИЙН АЖ АХУЙ

Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2908.5 мян.м² зам талбай цэвэрлэж, 19299.3 тн хог тээвэрлэжээ.

2025 оны 4 дүгээр сард тээвэрлэсэн хог өмнөх жилийн мөн үеэс 4 506.4 мян.м³ (21.2%) өссөн байна. Ажил үйлчилгээний орлого 2 143.8 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 642.5 (42.8%) сая төгрөгөөр өсчээ. Орлогын эх үүсвэрийг ангилбал 48.9 хувийг гэр хороолол, 43.8 хувийг зам талбай, 5.5 хувийг орон сууц, 1.8 хувийг албан газрын цэвэрлэгээ үйлчилгээнээс олсон орлого тус тус эзэлж байна.

Хүснэгт 11. ТОХИЖИЛТ, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛ, ОРЛОГО 2025 оны 4 дүгээр сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 IV	2024 IV	2025 IV	2024/2025	
					Дүн	Хувь
Цэвэрлэсэн талбай	мян.м ²	2 908.5	2 908.5	2 908.5	-	-
Тээвэрлэсэн хог	Тн	19 299.3	21 230.3	25 736.7	4 506.4	21.2
Орон сууц	Тн	-	-	-	-	-
Гэр хороолол	тн	16 932.0	17 506.2	22 400.4	4 894.2	28.0
Албан газар	тн	2 367.3	3 724.1	3 336.3	-387.8	-10.4
Зам талбай	Тн	-	-	-	-	-
Ажил үйлчилгээний орлого	сая.төг	1 117.3	1 501.3	1 143.8	642.5	42.8
Зам талбай	сая.төг	214.1	507.7	939.3	431.6	85.0
Гэр хороолол	сая.төг	792.4	819.3	1 048.3	229.0	28.0
Орон сууц	сая.төг	81.4	144.8	117.7	-27.1	-18.7
Албан газар	сая.төг	29.4	29.5	38.5	9.0	30.4

*Эх үүсвэр: Найши ХХК



ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

Нийслэлийн агаарын дундаж хэм 2025 оны 4 дүгээр сард 4.7 °C байв.

Нийслэлийн агаарын дундаж хэм 2025 оны 4 дүгээр сард 4.7 °C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 0.2 °C-аар хүйтэн, олон жилийн дундажтай харьцуулбал 3.0°C-аар дулаан байв. Энэ сарын хамгийн дулаан хэм 24.5°C,

хамгийн хүйтэн хэм -10.4 °C, хур тунадасны нийлбэр 0.8 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 19 метр секунд хүрсэн байна.


Хүснэгт 12. АГААРЫН БОХИРДОЛТ, мг/м3, IV сард

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO ₂	0.050	433	0.116	22	0.022
Азотын давхар исэл	NO ₂	0.050	468	0.173	67	0.034
Тоосжилт	PM ₁₀	0.100	524	0.590	175	0.096
	PM _{2.5}	0.050	515	0.058	2	0.018
Нүүрстөрөгчийн дутуу исэл	CO	10.000	1 307	5.434	1 307	0.787
Озон	O ₃	0.100	907	0.132	41	0.038

2025 оны 4 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад хүхэрлэг хий 0.002 мг/м³, азотын давхар исэл 0.003 мг/м³


-ээр, нүүрс төрөгчийн дутуу исэл 0.165 мг/м³ -ээр, PM 2.5 тоосонцор 0.004 мг/м³ -ээр, озон 0.014 мг/м³ -ээр тус тус бага, PM 10 тоосонцор 0.014 мг/м³ -ээр их байна.

Зураг 16. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ ХҮХЭРЛЭГ ХИЙН АГУУЛАМЖ, 15 станцын дундаж, мг/м3




Зураг 17.

УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ АЗОТЫН ДАВХАР ИСЛИЙН АГУУЛАМЖ, 16 станцын дундаж, мг/



Зураг 18.

УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ 10 МИКРОНООС БАГА ХЭМЖЭЭТЭЙ ТООСНЫ АГУУЛАМЖ, 18 станцын дундаж, мг/м3



Хүснэгт 13.

УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАХ БОДИСЫН АГУУЛАМЖ АГААРЫН ЧАНАРЫН СТАНДАРТ ХҮЛЦЭХ АГУУЛАМЖААС ДАВСАН ТОХИОЛДЛЫН ТОО, станц, 2025 оны IV сард

Станцын байршил	Хүхэрлэг хий (SO ₂)	Азотын давхар исэл (NO ₂)	Нүүрс төрөгчийн дутуу исэл (CO)	Тоосонцор (PM ₁₀)	Тоосонцор (PM _{2.5})
Нийт	22	67	0	175	2
Мишээл экспо				5	
Баруун 4 зам		18		4	
Тахилт	12	28		19	1
13-р хороолол		6		1	
Зуун айл				10	
Цахилгаан станц		5		26	
Ургах наран хороолол		5		20	1
Хайлааст	3			10	
Таван буудал				19	
Богд хааны ордон музей		3			
Шархад				5	
Налайх				8	
Яармаг				15	
Нисэх				3	
Толгойт	7			9	
Зурагт		2		1	
Амгалан				6	
Дамбадаржаа				14	
Баянхошуу					

Хүснэгт 14. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСЫН ХОНОГИЙН ДУНДАЖ АГУУЛАМЖ, мг/м3, IV сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл Экспо төв	Баруун дөрвөн зам	Тахилт	13-р хороо- лол	Зуун айл	Цахил- гаан станц	Ургах наран хороо- лол	Хай- лааст	Таван буудал
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	0.023	0.024	0.042	0.018	0.019	0.011	0.014	0.026	0.025
	Хамгийн их	0.047	0.043	0.096	0.039	0.04	0.022	0.031	0.116	0.048
	XXX*-с давсан %	-	-	40	-	-	-	-	11	-
	Хэмжилтийн тоо	29	29	30	30	30	30	30	27	30
Азотын давхар исэл NO ₂	Дундаж	0.009	0.052	0.106	0.037	0.012	0.026	0.039	0.024	0.025
	Хамгийн их	0.021	0.079	0.173	0.062	0.023	0.068	0.073	0.036	0.041
	XXX*-с давсан %	-	60	97	20	-	17	17	-	-
	Хэмжилтийн тоо	30	30	29	30	30	30	30	27	28
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	0.262	0.826	1.294	0.752	0.667	0.683	0.302	1.204	-
	Хамгийн их	2.19	2.381	5.434	3.472	1.981	2.492	1.109	3.784	-
	XXX*-с давсан %	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	83	86	90	90	90	90	90	80	-
Тоос PM ₁₀	Дундаж	0.079	0.076	0.121	0.058	0.086	0.25	0.188	0.084	0.116
	Хамгийн их	0.187	0.158	0.224	0.115	0.156	0.59	0.571	0.131	0.248
	XXX*-с давсан %	17	13	63	3	33	87	69	36	63
	Хэмжилтийн тоо	30	30	30	30	30	30	29	28	30
Тоос PM _{2.5}	Дундаж	0.023	0.018	0.029	0.016	0.014	0.026	0.024	0.021	-
	Хамгийн их	0.045	0.035	0.053	0.037	0.025	0.05	0.058	0.032	-
	XXX*-с давсан %	-	-	3	-	-	-	3	-	-
	Хэмжилтийн тоо	30	30	30	30	30	30	30	28	-
Озон O ₃ **	Дундаж	0.041	-	-	0.019	0.013	-	0.01	-	-
	Хамгийн их	0.069	-	-	0.036	0.023	-	0.017	-	-
	XXX*-с давсан %	-	-	-	-	-	-	0	-	-
	Хэмжилтийн тоо	89	-	-	90	90	-	80	-	-

үргэлжлэл

Агаарын бохирдлын үзүүлэлт		Богд хааны ордон музей	Шар- хад	Налайх	Яармаг	Нисэх	Толгойт	Зурагт	Амга- лан	Баян- хошуу
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	0.021	0.015	0.017	0.025	-	0.036	-	-	0.018
	Хамгийн их	0.044	0.032	0.039	0.049	-	0.079	-	-	0.033
	XXX*-с давсан %	-	-	-	-	-	23	-	-	-
	Хэмжилтийн тоо	25	27	30	30	-	30	-	-	26
Азотын давхар исэл NO ₂	Дундаж	0.036	0.037	0.024	0.031	-	0.024	0.032	0.027	-
	Хамгийн их	0.057	0.047	0.041	0.049	-	0.043	0.053	0.045	-
	XXX*-с давсан %	11	-	-	-	-	-	7	-	-
	Хэмжилтийн тоо	28	30	30	30	-	30	26	30	-
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	0.375	0.822	0.627	0.778	0.573	1.29	1.344	-	-
	Хамгийн их	0.916	5.02	2.238	2.9	1.559	4.767	5.103	-	-
	XXX*-с давсан %	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	84	90	90	87	90	88	79	-	-
Тоос PM ₁₀	Дундаж	0.048	0.069	0.084	0.094	0.066	0.079	0.057	0.062	-
	Хамгийн их	0.087	0.13	0.164	0.194	0.109	0.145	0.102	0.16	-
	XXX*-с давсан %	-	17	27	50	10	31	4	22	-
	Хэмжилтийн тоо	28	30	30	30	30	29	26	27	-
Тоос PM _{2.5}	Дундаж	0.008	0.011	0.011	0.007	0.017	0.023	0.023	0.013	0.022
	Хамгийн их	0.034	0.028	0.025	0.032	0.027	0.039	0.044	0.039	0.035
	XXX*-с давсан %	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	28	30	23	30	30	29	26	27	25
Озон O ₃ **	Дундаж	-	0.014	0.001	0.049	0.065	0.08	0.063	0.068	-
	Хамгийн их	-	0.021	0.004	0.095	0.121	0.132	0.107	0.116	-
	XXX*-с давсан %	-	-	-	-	8	30	5	5	-
	Хэмжилтийн тоо	-	44	90	87	88	87	76	86	-

Туул голын усны бохирдол:

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2025 оны 4 дүгээр сарын 12 - 13-ны өдөр хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд Амоны азот 23.5 дахин,

Эрдэс фосфор 6.0 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 17.9 дахин хүлцэх хэмжээнээс давж Туул голын ус бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 15. НИЙСЛЭЛИЙН ГАДАРГЫН УСНЫ НАЙРЛАГА, мг/м3, IV сард

Үзүүлэлт	Стандарт хэмжээ	“Туул-Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
		Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч	O ₂	≥6	10.97	Хэвийн	6.04 хэвийн
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	BXX ₅	≤3	2.7	Хэвийн	53.7 17.9 дахин
Нитритийн нэгдэл	NO ₂	≤0.02	0.007	Хэвийн	0.319 16.0 дахин
Амоны азот	NH ₄	≤0.5	0.07	Хэвийн	11.78 23.5 дахин
Эрдэс фосфор	P	≤0.1	0.016	Хэвийн	0.603 6.0 дахин

Байгаль орчны зөрчил:

Нийслэлийн хэмжээнд 2025 оны эхний 4 сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 411 зөрчлийг илрүүлжээ. Илрүүлсэн нийт зөрчлийн 81.5 хувийг ан амьтны зөрчил, 11.7 хувийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, 2.2 хувийг усны зөрчил, 1.7 хувийг газрын

хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 1.0 хувийг ургамал хөрсний бохирдолын зөрчил, 0.5 хувийг ойн зөрчил, 0.2 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 1.2 хувийг бусад зөрчил эзэлж байна. Илрүүлсэн нийт зөрчилд 84.6 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Хүснэгт 16. БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗӨРЧИЛ, төрлөөр

Илрүүлсэн зөрчил, Төрлөөр	2025 I-IV		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль (сая төгрөг)
Бүгд	417	411	84.6
Ой	3	2	-
Ан, амьтан	338	335	21.3
Газрын	-	-	-
Ус	9	9	24.0
Ургамал, хөрсний бохирдол	4	4	0.1
Агаар, химийн хорт бодис	1	1	-
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	7	7	5.3
Геодези зураг зүй, кадастр	-	-	-
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	48	48	32.8
Бусад	7	5	1.1

Аюулт үзэгдэл, осол:

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2025 оны эхний 4 сард 57 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 55.1 хувиар буурсан байна. Гамшгийн улмаас 10 хүн амь насаа

алдаж, 63 хүнийг аварч, гамшгийн уршгийг арилгах ажилд нийт 1281.2 сая төгрөг зарцуулжээ.


Хүснэгт 17. ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, дүүргээр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Дүүрэг	2020 I-IV	2021 I-IV	2022 I-IV	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV	2025 2024 Хувь
Нийслэлийн дүн	864	617	798	607	582	1 033	77.5
Багануур	13	11	9	7	12	46	3.8**
Багахангай	3	-	3	2	3	6	2.0**
Баянгол	101	68	78	64	50	94	88.0
Баянзүрх	194	150	215	155	157	230	46.5
Налайх	23	18	19	19	28	49	75.0
Сонгинохайрхан	231	149	202	148	139	265	90.6
Сүхбаатар	120	81	107	88	67	109	62.7
Хан-Уул	83	67	91	60	67	147	2.2**
Чингэлтэй	96	73	74	64	59	87	77.5

2025 оны эхний 4 сард ахуйн 1033 гал түймэр гарч өмнөх оны мөн үеэс 77.5 хувиар нэмэгдсэн байна. Гал түймрийн улмаас 16 хүн түлэгдэж гэмтэн, 8 хүн эндсэн байна. Худал дуудлага 19 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.1 дахин их байна.

Гал түймрийн аюулаас 1569 хүн, 261 байшин барилга, 138.7 сая төгрөгийн эд хөрөнгийг аварсан байна. Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал санамсаргүй байдлаас 749 (72.5%), цахилгаанаас 255 (24.7%), санаатай үйлдлээр 3 (0.3%), бусад шалтгаанаар 26 (2.5%) гал түймэр гарчээ.

Зураг 19. ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, байршлаар, эзлэх хувь



Гал түймэрт 440 гэр, орон сууц, 49 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 48 машин техник, 125 малын хашаа саравч, бусад төрлийн 371 объект өртжээ. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 689, төрийн өмчийн 252, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 92 объект өртөж, нийт 1941.9 сая төгрөгийн хохирол учирсан байна.

Нийслэлийн Онцгой байдлын газраас 2025 оны эхний 4 сард 125 барилгын зураг төсөл,

ашиглалтад хүлээн авч буй 181 барилгад хяналт тавьж ажиллажээ. Түүнчлэн 2026 объектод үзлэг шалгалт хийж, 8912 галын зөрчил илрүүлж, байгууллага, албан тушаалтан, иргэнд 465 заавал биелүүлэх албан шаардлага, 924 мэдэгдэл хүргүүлж, 127.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



VII. ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Дүүргийн хэмжээнд нийт 26787 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4675 (14.9%) зөрчилөөр буурсан байна.

Чингэлтэй дүүргийн Тээврийн Цагдаагийн албаны хэлтсийн алба хаагчид 2025 оны эхний 4 сард гудамж замд хийсэн хяналт шалгалтаар 26787 зөрчил илрүүлж, 554

хүнийг торгож, эрх хасах, 231 хүнийг торгох, 77 хүнд шүүхээр баривчлах шийтгэл оногдуулсан байна.

Хүснэгт 18.

ТОРГУУЛСАН ЖОЛООЧИЙН ТОО, торгуулийн хэмжээ

Торгууль	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV
Торгуулсан хүний тоо	42 992	31 462	26 787
Торгуулийн нийт хэмжээ /сая төгрөг/	1 160.0	506.5	1 029.4

Хүснэгт 19.

ЗАМ ТЭЭВРИЙН ЗӨРЧИЛ, зөрчлийн хэлбэрээр

Зөрчлийн хэлбэр	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV
НИЙТ ЗӨРЧИЛ	43 990	31 459	26 787
Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон	960	309	554
Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, боловч тээврийн хэрэгсэл жолоодсон	371	293	563
Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон	2 837	2 352	3 880
Хамгаалах бүс хэрэглээгүй	1 627	1 723	5 607
Хориглосон нөхцөлөөр зогссон	13 392	6 863	2 751
Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн	7	20	12
Эгнээ байраа буруу эзэлсэн	921	1 002	862
Бусад зөрчил	23 872	18 897	12 558

*Эх үүсвэр: ЧД-ийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтэс



Х. ТӨРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

Иргэний бүртгэлийн үйлчилгээ: 2025 оны эхний 4 сарын сарын байдлаар иргэний бүртгэлийн 9 төрлийн үйлчилгээг 23633 иргэнд үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 2345 (9.0%) хүнээр буурсан үзүүлэлттэй байна. Хүүхэд үрчлэлт, эцэг тогтоох, лавлагаа авах үйлчилгээнүүд өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 20.

ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ХҮНИЙ ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР

Үзүүлэлт	2024 I-IV	2025 I-IV	2024/2025	
	Дүнгээр		Дүн	хувь
Нийт	25 978	23 633	- 2 345	-9.0
Шинэ төрсөн	957	771	- 186	-19.4
Гэрлэлт	228	193	- 35	-15.4
Гэр бүл цуцлалт	129	84	- 45	-34.9
Хүүхэд үрчлэлт	10	15	5	50.0
Эцэг тогтоосон	32	36	4	12.5
Овог, нэр өөрчлөх	42	42	-	-
Шилжин ирсэн	2 822	1 044	- 1 778	-63.0
Лавлагаа	16 630	18 995	2 365	14.2
Иргэний үнэмлэх олголт:	5 128	2 453	- 2 675	-52.2
16 нас хүрч шинээр авсан	1 168	614	- 554	-47.4
Дахин олголт	3 960	1 838	- 2 122	-53.6

* Эх үүсвэр: Иргэний бүртгэлийн хэлтэс

Онцгой байдал:

2025 оны эхний 4 сард ахуйн 198 гал түймэр гарч өмнөх оны мөн үеэс 61.0 хувиар нэмэгдсэн байна. Гал түймрийн аюулаас 612 хүн, 47.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг аварсан байна. Худал дуудлага 4 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 50 хувиар буурчээ.

Хүснэгт 21.

ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, зарцуулсан хөрөнгийн үзүүлэлт, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Дуудлагын тоо	193	163	246	83	50.9
Худал дуудлага	-	8	4	-4	-50.0
Гал түймрийн тохиолдлын тоо	168	123	198	75	61.0
Унтраасан гал түймрийн тоо	140	96	187	91	94.8
Ашигласан ус, тонн	108	477.1	540.5	63.4	13.3
Ашигласан шатахуун /дизель/, литр	1 210	3 709.0	4 529.9	820.8	22.1
Ашигласан хөөс, литр	-	150	558	408.0	2.7'
Зарцуулсан хөрөнгө, сая.төг	7.5	14.3	14.7	0.4	3.1
Аварсан хүний тоо	121	163	612	449	2.7'
Учирсан хохирол, сая.төг	920.0	15 636.8	47 203.4	31.6	2.0'

¹-дахин их * Эх үүсвэр: Онцгой байдлын хэлтсийн галын мэдээ

2025 оны эхний 4 сард ахуйн 198 гал түймэр гарч өмнөх оны мөн үеэс 61.0 хувиар нэмэгдсэн байна. Гал түймрийн аюулаас 612 хүн, 47.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг аварсан байна. Худал дуудлага 4 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 50 хувиар буурчээ.

Зураг 20.

ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, зарцуулсан хөрөнгийн үзүүлэлт, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

2025 оны эхний 4 сард нийт 246 гал түймэр, гамшиг ослын дуудлага бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 83(50.9%)-аар өсчээ.



Дуудлагын тоо
246



Гал түймэр
198



Аварсан хүний тоо
612



Ашигласан шатахуун
820.8



Зарцуулсан мөнгө /сая.төг/
14.7



Худал дуудлага
4

Эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ: 2025 оны эхний 4 сарын байдлаар 7 төрлийн үйлчилгээг нийт 10101 иргэн, аж ахуй нэгж байгууллагад үзүүлж, үйлчилгээний хөлсөнд 187 сая төгрөгийн хураамж авсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс үйлчилгээ авсан хүн 2246 (28.6%) өсөж, үйлчилгээний хөлс 2.4 (1.3%) сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 22.

ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТОО, ТӨРЛӨӨР

Үйлчилгээний төрөл	2025 I-IV сар					
	Эд хөрөнгийн бүртгэл		Газар		Газраас бусад	
	Үйлчилгээ ний тоо	Үйлчилгээ ний хөлс (сая.төг)	Үйлчилгээний тоо	Үйлчилгээ ний хөлс (сая.төг)	Үйлчилгээ ний тоо	Үйлчилгээ ний хөлс (сая.төг)
Нийт	4 873	83 745	1 942	18 347	3 286	84 986
Анхны бүртгэл	337	1 051	93	480	239	651
Өмчлөх эрх шилжих гэрээ	1 119	22 328	401	8 000	718	14 328
Барьцааны гэрээ	3 187	77 341	1 157	8 711	2 030	68 630
Бусад гэрээ	26	130			26	130
Бүртгэлд өөрчлөлт оруулах	362	2 324	181	1 132	181	1 192
Урьдчилсан тэмдэглэл	1		1	-	-	-
Лавлагаа хуулбар	201	81	109	24	92	55

*Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтэс

Улаан загалмай: 2025 оны эхний 4 дүгээр сарын байдлаар 9052 хүнд 9300 мянган төгрөгийн халамж үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 737 хүнээр буурч, зарцуулсан зардал 1230 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Хүснэгт 23

ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ, ТӨРЛӨӨР ЭХНИЙ 4 САРД

Үзүүлэлт	2024 I-IV			2025 I-IV		
	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/
Дүн	177	9789	10530	194	9052	9300
Халамж үйлчилгээ	16	682	7000	18	468	1250
Халамжийн чиглэлээрх сургалт, сурталчилгаа	34	443	1300	36	1072	1400
Анхны тусламжийн сургалт	44	1097	300	15	483	300
Эрүүл мэндийг дэмжих сургалт, сурталчилгаа	21	691	300	6	121	190
Гамшгийн тусламж	2	10	350	-	-	-
Гамшгийн талаарх сургалт, сурталчилгаа	8	3100	600	13	2343	1340
Донорын өдөрлөг, сурталчилгаа	6	2900	60	9	502	
Хүүхэд залуучуудын хөдөлгөөний чиглэлээрх сургалт, сурталчилгаа	5	56	20	27	1640	2620
Хүмүүнлэгийн хууль эрх зүй, 7 зарчим, ТУЗХА-ны сурталчилгаа	41	810	600	70	2423	2200

*Эх үүсвэр: Улаан загалмайн хороо

Халамжийн чиглэлээр сургалт, сурталчилгааг 18 удаа зохион байгуулж 468 иргэн, анхны тусламжийн сургалт 15 удаа зохион байгуулж 483 иргэн, хүүхэд залуучуудын хөдөлгөөний чиглэлээр сургалтыг 27 удаа зохион байгуулж 1640 иргэн, хүмүүнлэгийн хууль эрх зүй, 7-н зарчим, төр, улаан загалмайн хамтын ажиллагааны сурталчилгааг 70 удаа зохион байгуулж 2423 иргэнийг тус тус хамруулсан байна.

Захиргааны мэдээлэл: Иргэдээс 2025 оны эхний 4 сард 1 226 өргөдөл, гомдол ирснээс 898 (73.2%)-ыг хуульд заасан хугацаанд нь шийдвэрлэж, 328 (26.8%) нь шийдвэрлэх шатандаа хянагдаж байна.

Хүснэгт 24.

ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЭДЭЭ, хүлээн авсан нэгжийн ангиллаар, 2025 оны эхний 4 сард

Ангилал	2025 I-IV	Үүнээс:	
		Шийдвэрлэх шатандаа байгаа	Шийдвэрлэж хариу өгсөн
Нийт	1 226	328	898
Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв	12	3	9
Нутгийн захиргааны байгууллагууд	664	185	479
1800-1200 дугаарын оператор	73	23	50
11-11 төвөөс ирсэн	467	114	353
Гар утасны аппликэйшнээр ирсэн	-	-	-
Мессеж	-	-	-
E-Service	8	3	5
Facebook	-	-	-
Дижитал сити	-	-	-
Хороо бүртгэсэн	2	-	2
НМХГ тусгай дугаар	-	-	-

* Эх үүсвэр: Дүүргийн өргөдөл, гомдлын мэдээ

БҮЛЭГ

ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2023-2025 он	
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	Г. Пүрэвсүрэн
I	Эрүүл мэнд	Б.Мишээлт
II	Нийгмийн даатгал, халамж	Б.Мишээлт
III	Гэмт хэрэг	Г. Пүрэвсүрэн
IV	Төсөв	Г. Пүрэвсүрэн
V	Хэрэглээний үнэ	Л. Шинэтуяа
VI	Нийтийн аж ахуй	Л. Шинэтуяа
VII	Дүүргийн аюулгүй байдал	Г. Пүрэвсүрэн
VIII	Төрийн үйлчилгээ	Б. Мишээлт Л. Шинэтуяа



Авлигатай тэмцэх газар

Хэрэв танд:

-Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл;

-Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан "Авлигын гэмт хэрэг"-ийн шинжтэй гомдол мэдээлэл өгөхөөр бол Авлигатай тэмцэх газарт хандана уу;

Үүнд:

22.1 дүгээр зүйл /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/;

22.3 дугаар зүйл /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах/;

22.4 дүгээр зүйл /Нийтийн албан тушаалтан хохууль авах/;

22.5 дугаар зүйл /Хохууль өгөх/;

22.6 дугаар зүйл /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хохуульдах/;

22.7 дугаар зүйл /Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх/;

22.8 дугаар зүйл /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/;

22.9 дүгээр зүйл /Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/;

22.10 дугаар зүйл /Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/;

22.11 дүгээр зүйл /Дураараа аашлах/;

22.12 дугаар зүйл /Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/;

22.13 дугаар зүйл /Хохууль авах/;

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТОО /ХҮСНЭГТЭЭР ХАРУУЛБАЛ/



Авлигыг мэдээлэх утас

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ Хүлээн авах суваг

Авлигатай тэмцэх газарт ирж биечлэн
Утсаар: (976)-110 /Ярианы төлбөргүй/
дугаараар

Факс: (976)-11-311919

Цахим шуудангийн хаяг: contact@iaac.mn

Шуудан холбоогоор: Улаанбаатар хот 14250,

Сүхбаатар дүүрэг, 5 хороолол, Сөүлийн

тудамж 41 хаягаар

Веб сайт: iaac.mn

Авлигын эсрэг



Үгүй гэж хэлээд өөрчилъё! 110

